

Good Practice

2014.11.15

Дугаар 9

Good Practice-ийн шалгаруулалт

Project E-News

**【Инженерийн дээд боловсролыг дэмжих төсөл】
Хөтөлбөр хариуцсан ажилтан Ч. Оюунцэцэг**

Volunteer E-News

【Эмчилгээний биеийн тамирын арга зүй】

**Сайн дурынхныг хариуцсан
ажилтан Ц. Орхонтуяа**

Сургалт төгсөгчдийн булан

**【ЖАЙКА-гийн урилгаар ЖАЙКА сургалт
төгсөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүд
Япон улсад айлчилсан талаарх товч тайлан】**

**ЖАЙКА сургалт төгсөгчдийн холбооны Нарийн
Бичгийн Дарга**

Л.Дондог

Бэлтгэсэн : П. Алтансүх

Та Япон улсад сургалтанд оролцох хугацаандаа олж авсан мэдлэг, туршлагаа өөрийн ажлын байран дээр хэрэгжүүлж байгаа юу ?

“Good Practice” буюу сайн туршлагын шалгаруулалт нь энэ жил анх удаа хэрэгжиж буй юм. 2015 оны 3 сард болох Бүх гишүүдийн хурлын өмнө Жайка-гийн сургалтанд оролцогчдын “Good Practice”-ийг цуглуулан, сонгогдсон сайн туршлагуудаар танилцуулга бэлтгэн гаргах ба шалгарсан материалуудыг Бүх гишүүдийн хурал дээр танилцуулах ба Холбооны тэргүүний нэрэмжит, Жайка-ийн төлөөлөгчийн газрын нэрэмжит шагнал гардуулна. Холбооны гишүүн бус төгсөгч сонгогдсон бол холбоонд элсэх шаардлагатай болно.

Японд суралцан олж авсан туршлага, мэдлэгээ Монголд буцаж ирээд өөрийн ажлын байран дээр хэрэгжүүлэн, олсон амжилтаа бусдад сурталчлан таниулах нь маш гайхалтай үйл ажиллагаа ба энэ шалгаруулалтанд оролцох хүмүүс олон байгаа байх гэж найдаж байна. Энэ шалгаруулалтыг зөвхөн энэ жил ганц удаа зохион байгуулах бус цаашид жил бүр зохион байгуулахаар төлөвлөж байна.

*“Good Practice” гэдэгт:

Японд суралцсан зүйлээ ажил дээрээ болон тухайн салбартаа нэвтрүүлсэн

Японд суралцсан зүйлдээ тулгуурлан, ажил дээрээ тулгамдаад байсан асуудлыг шийдсэн

Японд суралцсан зүйлээ ашиглан, ажил дээрээ шинэ үйл ажиллагааг эхлүүлсэн гэх мэт

Материал хүлээж авах хугацаа: 12 сарын 10 хүртэл

Материал хүлээж авахад тавих шаардлага: Монголд буцаж ирээд хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа тухай шалгаруулалтын хуудсын 1- 6 хүртэлх асуултанд хариулан и-мэйлээр явуулна уу.

Дэлгэрэнгүй мэдээлэл:

Жайка-ийн Сургалт Төгсөгчдийн Холбооны зохицуулагч Дэлгэрсүрэнтэй холбогдоно уу.

Утас: 325939, 311329

E-mail: jicamg-alumni@jica.go.jp

※Мөн шалгаруулалтын хуудас болон бусад холбогдох мэдээллийг доорх линкээр орж авч болно.

www.jaam.mn,



Жайка Монгол дахь төлөөлөгчийн газар
Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3,
Улаанбаатар хот
Утас: 976-11-325939, 312393
Факс: 976-11-310845
E-mail: mg_oso_rep@jica.go.jp
<http://www.jica.go.jp/mongolia/index.html>

<https://www.facebook.com/JICA-Alumni-Association>

Инженерийн дээд боловсролыг дэмжих төсөл

ЖАЙКА нь өнөөг хүртэл буцалтгүй тусламжийн хүрээнд сурагчдын суралцах орчныг сайжруулах зорилгоор сургуулийн барилга байгууламжийг барих, багшийн заах арга зүйг сайжруулах зэрэг бага дунд боловсролын салбарт техникийн хамтын ажиллагааг амжилттай хэрэгжүүлж ирсэн.

2014 оны 3 сарын 11-нд Монгол улсын засгийн газартай байгуулсан “Инженерийн дээд боловсролыг дэмжих төсөл”-ийн иений зээлийн гэрээнд гарын үсэг зурснаар дээд боловсролын салбарт хамтын ажиллагааныхаа хүрээг өргөжүүлэн тэллээ.

Монгол улсын эдийн засгийн эрчимтэй хөгжилтэй уялдан аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх хэрэгцээ шаардлага ихэсэхийн хэрээр инженерийн мэргэжлээр их дээд сургуульд элсэгчдийн тоо ч мөн эрс нэмэгдэж байна. Иймд инженерийн дээд боловсролын чадварлаг боловсон хүчинг бэлтгэх шаардлага тулгарсан.

Тиймээс энэхүү төсөл нь Монгол улсын инженерийн дээд боловсролын байгууллагын чадавхийг сайжруулах (Багш нарыг бэлтгэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах, тоног төхөөмжийг нийлүүлэх) урт болон дунд хугацааны түвшинд аж үйлдвэрийн салбарт дутагдаж буй чадварлаг боловсон хүчинг дотооддоо бэлтгэх орчинг бүрдүүлэхээс гадна Япон улсад богино хугацааны сургалтанд хамруулан хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, үйлдвэрлэлийн чадавхи, олон талт хөгжлөөр дамжуулан эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Төслийн товч агуулга:

Зээлийн мөнгөн дүн: 7.535 тэрбум иен (ойролцоогоор 127 тэр бум төгрөг)

Эргэн төлөлтийн хугацаа: 20 жил

Үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа: 6 жил

Төслийн хүрээнд явагдах үйл ажиллагаа:

1. Олон улсын хамтарсан боловсролын хөтөлбөр (бакалаврын хос хөтөлбөр- 320 хүн, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл)

2. Багш бэлтгэх хөтөлбөр (зэргийн сургалт: Магистр-100 хүн, доктор- 60 хүн)
3. Сургалт болон судалгааны тоног төхөөрөмж
4. Япон Монголын их дээд сургуулиудын хамтарсан судалгаа (320 хүн)
5. Косэн суралцуулах хөтөлбөр (200 хүн)

Төслийн тухай сүүлийн үеийн мэдээ

2014 оны 10 сарын 20-д КОСЭН хөтөлбөрийн бэлтгэл сургалтын нээлт зохион байгуулагдлаа. Нээлтэд Япон улсын элчин сайд Шимизү Такенори болон БШУЯ-ны сайд Гантөмөр нар болон төслийн холбогдох хүмүүс, бэлтгэл сургалтанд сонгогдсон 47 оюутан оролцлоо. Гантөмөр сайдын зүгээс “Аливаа асуудлыг шийдэх чадвартай, эрдэм мэдлэгийг гартаа оруулсан шинэ үеийн сайн инженер болоорой ” хэмээн оюутнуудад хандан захив.



Энэ оны 9 сард элсэн орсон оюутнууд 1.5 жилийн бэлтгэл сургалтанд хамрагдсны дараа шалгалт өгөн тэнцсэн оюутнууд нь Японы КОСЭН-ы 3-р курст шилжин суралцах юм. Бүртгэлийн үед Япон хэлтэй оюутнууд ч байсан ба эдгээр оюутнуудын хувьд бэлтгэл сургалтанд суулгүйгээр дараа жилийн 4 сараас шууд Японд суралцах төлөвлөгөөтэй байна



Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэхийн ялдамд энэ удаа Монгол улсын спортын салбарт бараг байдаггүй боловч нэн шаардлагатай нэгэн мэргэжилтний тухай танилцуулъя.

2014.8.18~9.29-ныг хүртэл УБ хот дахь ҮБТДС-д богино хугацааны сайн дурын гишүүнээр Сакурай Норико нь Athletic Trainer буюу эмчилгээний биеийн тамирын арга зүйчээр тус дээд сургуулийн мэргэжлийн багш болон төгсөх курсийн оюутнуудад онол дадлагын хичээлийг хослуулан заалаа.

Ажиллах хугацаа хэдий богино байсан ч хүлээн авч ажиллуулсан сургуулийн хамт олон, сайн дурын гишүүн мөн бидний хичээл зүтгэлийн үр дүнд энэ удаагийн хамтын ажил өндөр ач холбогдолтой байж, цаашид энэ мэргэжилтнийг Монголд бэлтгэх их ажлын эхлэл суурь тавигдсанд бид маш их баяртай байна.

Ингээд Сакурай Норико сайн дурын гишүүний тухай болон athletic trainer гэх мэргэжилтэн нь хаана ямар үүрэгтэй хэрхэн ажилладаг тухай товч танилцуулъя.

Сакурай Норико нь Японы Ниттай биеийн тамирын их сургуулийн Athletic Trainer-н мэргэжилтэн бэлтгэх багшаар ажилладаг ба мөн Японы биеийн тамирын холбооноос итгэмжлэгдэн, Японы 7 гишүүнтэй өсвөрийн Регбигийн эмэгтэй шигшээ багийн Athletic Trainer-ээр ажилладаг арвин туршлагатай хүн юм. Энэ удаа дээр дурдсаны дагуу Монголын ҮБТД сургуулийн багш оюутнуудад Athletic Trainer-н тухай дэлгэрэнгүй ойлголт, боолт, сунгалт, тамирчдад үзүүлэх анхны тусламж мөн төгсөгчид болон холбогдох байгууллагын мэргэжилтэнүүдэд “Гэмтэл бэртэлгүй спорт” гэсэн чиглэлээр семинар зохион байгуулсан.



Athletic Trainer юу хийдэг вэ?

1. Спортын бэртэл гэмтлээс хамгаалах

Спортын бэртэл гэмтлээс гадна, бие махбодийн дотоод үйл ажиллагааны хямрал, шим тэжээлийн дутагдлаас үүдэн гарах өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх

2. Спортын талбар дахь гэмтлийн үеийн анхны тусламж

Гэмтэл бэртлийн үед шаардлагатай анхны тусламжийг үзүүлж, хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх

3. Биеийн тамирын сэргээн засал

Тухайн тамирчин тэмцээний бэлтгэл сургуулилтаа хэвийн байдалтай үргэлжүүлэх хүртэл нь шаардлагатай хөдөлгөөн заслыг хийнэ.

4. Conditioning Бүх талын бэлтгэлийг хангах


Тухайн тамирчны зорьж буй тэмцээн, уралдаанд нь хамгийн дээд хэмжээнд хүртэл бэлтгэнэ.

5. Ажиглалт ба шинжилгээ

Тамирчдын эрүүл мэндийн байдлыг оновчтой үнэлж, мэдэх зорилготой

6. Эрүүл мэндийн хяналт оролцоо

Тамирчны эрүүл мэндийг хянахын тулд шаардлагатай үнэлгээний аргачлал боловсруулах, бэлтгэх, багийн бусад гишүүдэд мэдээллэж, зохистой хамтран ажиллах гэх мэт маш олон үүрэгтэйгээр ажилладаг.



Японд дээрхийн дагуу нэг тамирчинг олон талаас нь дэмжлэг үзүүлж, түүний хэрээр дэлхийд өндөр амжилт үзүүлж байгаа бол манай улсад нэг тамирчинд эдгээр бүх хүмүүс бүгд үйлчилж чадахгүй байгаа ч сүүлийн үед манай тамирчдын дэлхийн тавцанд гаргаж буй амжилт өссөөр байгаа тул бидний зүгээс Athletic Trainer буюу эмчилгээний биеийн тамирын арга зүйч гэдэг мэргэжилтэнг Монгол улсдаа бэлтгэн, 2020 оны Токиогийн олимпд бидний бэлтгэсэн мэргэжилтэн үндэсний шигшээ багийн арга зүйчээр ажиллаж байх тэр сайхан мөчийг төсөөлөн, улам хичээнгүйлэн ажиллаж байна.

Сургалт төгсөгчийн булан

Удирдах зөвлөлийн гишүүдийн Япон улсад айлчилсан ажилласан тайлан

2014 оны 8 сарын 30-аас 9 сарын 5-ны хооронд Японы Жайка Олон Улсын Байгууллагын дэд ерөнхийлөгч ноён Танака-гийн урилгаар ЖАЙКА сургалт төгсөгчдийн холбооны Тэргүүн, УИХ-ын гишүүн, Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны дарга Ц.Оюунбаатар, Ерөнхий Нарийн бичгийн дарга, Нягтлан бодогчдын хүрээлэнгийн захирал Л.Дондог, Удирдах зөвлөлийн гишүүн Р.Энхтуул нар Япон улсад ажлын айлчлал хийлээ.



Айлчлалын хүрээнд Японы Гадаад харилцааны яамны улс төрийн нэгдүгээр орлогч сайд ноён Кихара Сеижи, Жайка Олон Улсын Хамтын ажиллагааны Байгууллагын дэд ерөнхийлөгч ноён Ичикава Масаказу болон Зүүн-Төв азийн бүс нутаг хариуцсан газрын дарга хатагтай Янагисава Ки, Сургалт хариуцсан газрын дарга ноён Ватанабэ Масао нартай уулзан цаашдын хамтын ажиллагааны тал дээр санал солилцсон юм.

Тухайн үед Япон улсад суралцаж байгаа Монгол суралцагчдын сургалтын байдалтай танилцах зорилгоор Токио дахь сургалтын төв болон Ёкохама дахь сургалтын төвөөр зочилсон юм.



Ёкохама сургалтын төвийн дарга Обата-гийн н хамт

Энэ удаагийн айлчлалын бас нэг том зорилго бол Монгол улсад хөрөнгө оруулалт хийж байгаа болон хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байгаа Японы хувийн хэвшлийн компаниудтай уулзах явдал байсан юм.

Тиймээс Шинэ Улаанбаатар олон улсын онгоцны

буудлын бүтээн байгуулалтын төсөлд хөрөнгө оруулалт хийж буй Мицibuши корпораци, төв болон зүүн азид эрчим хүч түгээх Нар болон Салхин цахилгаан станц барих ажилд хөрөнгө оруулалт хийж буй Soft bank корпорацийн удирдах ажилчидтай уулзалт зохион байгуулсан.

Мөн Японы гадаад хаудалдааны байгууллага (JETRO)-ын төлөөлөгчидтэй уулзаж, Монгол хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байгаа байгууллагуудыг мэдээллээр хангах зэрэг өөрсдийн саналаа дэвшүүлэн санал бодлоо солилцсон юм.

ЖАЙКА-гийн удирдлагын зүгээс холбоо цаашид одоогийн хийж байгаа ажлаа улам эрчимжүүлэн ажиллахын тулд дараах чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллахыг санал болгов. Үүнд:

1. ЖАЙКА-гийн зүгээс шинээр хэрэгжүүлэх төсөл болон одоо хэрэгжиж буй төслийн судалгааны ажилд холбооны мэдээллийн сүлжээг ашиглах. Жишээ нь:
 - Тухайн салбарын мэргэжилтэн (Холбооны гишүүн) -гүүдээс мэдээлэл авах, тэднээр дамжуулан мэдээлэл цуглуулах
 - Мэйл зэргийг ашиглан нэгэн зэрэг хэд хэдэн хүнд асуулт тавьж, хариулт авах.
2. ЖАЙКА-ийн одоо хэрэгжиж байгаа болон шинээр хэрэгжих төслийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээллэх, таниулах.
3. Монголд бизнес эрхлэх сонирхолтой хувь хүн болон албан байгууллагуудад хэрэгцээт мэдээллээр хангах
 - Мэдвэл зохих дүрэм журамтай холбоотой мэдээлэл
 - Холбогдох хуулийн мэдээлэл
 - Монгол-Япон төвөөр дамжуулан хувь хүн, байгууллагуудад мэдээл түгээх
4. Японы хувь хүн, албан байгууллагуудад хандан семинар зохион байгуулах
 - Хоёр орны онцлогийг харьцуулан танилцуулах. Үүнд холбооны гишүүд болон JDS зэрэг Жайка-гийн урт хугацааны зэрэг олгох сургалтын төгсөгчдийг хамруулан зохион байгуулах боломжтой.
5. ЖАЙКА-гийн сургалт төгсөгчдийн талаар мэдээллэх
 - Сургалтаас олж, мэдэж авсан мэдлэгээ ажлын байран дээр хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай
 - Мөн мэдлэгээ бусдад түгээж байгаа арга барил (семинар зохион байгуулах зэрэг)

Монголын төлөөлөгчид ЖАЙКА байгууллагын удирдлагуудын зүгээс тавьж байгаа саналыг бүрэн хүлээн авч байгааг илэрхийлэхийн ялдамд ажлын цар хүрээ өргөжиж байгаа нөхцөлд холбоонд үзүүлдэг санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх, холбооны удирдах зөвлөлийн гишүүдийг идэвхижүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байхыг хүссэн.

Бэлтгэсэн. Л.Дондог